



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Мэргэжлийн ангийг нэмж, томилгоожуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3, 33.1.4, 33.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны мэргэжлийн ангийн даргаар дараах эрх бүхий албан тушаалтнуудыг нэмж томилсугай.

П.Ганхүү	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн мэргэжлийн ангийн даргаар
Ц.Түмэнцогт	“Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн мэргэжлийн ангийн даргаар
Д.Амар	“Эрдэнэс метан” ХХК-ийн мэргэжлийн ангийн даргаар
Б.Ууганхүү	“Эрдэнэс ассет менежмент” ХХК-ийн мэргэжлийн ангийн даргаар
Х.Наранхүү	“Эрдэнэс Тавантолгой Майнинг” ХХК-ийн мэргэжлийн ангийн даргаар
Н.Удаанжаргал	“Тавантолгой Төмөр зам” ХХК-ийн мэргэжлийн ангийн даргаар
Х.Бадамсүрэн	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын мэргэжлийн ангийн даргаар
Б.Мөнхбат	“Монголросцветмет” ТӨҮГ-ын мэргэжлийн ангийн даргаар
Д.Далайжаргал	“Мон атом” ТӨҮГ-ын мэргэжлийн ангийн даргаар
Э.Номинчулуун	“Багануур” ХК-ийн мэргэжлийн ангийн даргаар
Ц.Энхтүвшин	“Шивээ-Овоо” ХК-ийн мэргэжлийн ангийн даргаар


2. Гамшгаас хамгаалах асуудлыг хариуцах шуурхай штабыг өөрийн байгууллага дээр томилж, Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж ажиллахыг мэргэжлийн ангийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Мэргэжлийн ангийн дарга нарыг Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны чиг үүргийн дагуу удирдан зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабын дарга Г.Нандинжаргалд даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Г.Ганхүү/-д зөвшөөрсүгэй.

САЙД

Д.СУМЬЯАБАЗАР



08 0080